

МАНЖИЙН ТҮРЭМГИЙЛЛИЙН ЭСРЭГ БАРГЫН ГАНТӨМӨРИЙН ТЭМЦЭЛ

Ж. Өлзий

XVII зууны дунд үеийн Оросын хуучны сурвалж бичиг, мөн Оросын эрдэмтэн А. М. Баранова, зөвлөлтийн эрдэмтэн С. Д. Дылыков нарын бичсэн ном зохиолуудад Барга, бутхан Дагуур нар болон тэдний ноён Гантөмөрийн тухай тодорхой бичсэн зүйл байдаг. Гантөмөр бол Шилка голын дагуу нутаглаж байсан Түнгүүс удмын Нельют (татар) аймгийн тэргүүн байсан бөгөөд Нэрчүүд төрсөн ажээ. Гантөмөр ноёны харьяат нутаг бол Эргүннэ голоос зүүн зүгт Нуун мөрөн хүртэл, Амар мөрнөөс өмнө зүгт Соёлж уул хүрч байжээ.

Тус районы түнгүүс угсааны эвэнки, хамниган, солон, орчоон, якут болон монгол угсааны чивчин барга, буриад, халх, дагуур зэрэг олон угсаатан ястнаас бүрэлдсэн¹ аймаг, угсаатныг Гантөмөр тэргүүлж албат иргэдээ удтал бие дааж удирдан захирч байжээ.

Баргын түүхээс дурдвал, Монголын нууц товчооны 239-р талд 1207 онд Монгол улс нь ойрад (ойн ард), буриад, барга зэрэг аймгийг оруулан авч Зүчид захируулсан байна. 1368 онд Хятадын Мин улс байгуулагдан, Монголыг түрэмгийлсэн боловч Монгол улс засгийнхаа эрхийг, барга, дагуур нар орон нутаг бүрэн эрхт байдлаа хамгаалан үлджээ. Хятадын судлаач Сун Сялин 1908 онд Баргын тухай бичихдээ Барга нь чухамдаа Мин улсын үед бүлэг хүмүүс өөрийн нутгийн төлөө тэмцэгч цэрэг дайны нум сумаар зэвсэглэсэн сайн эрчүүдийн нутаглах газар байв гэжээ. Түүнчилэн жужан, кидан, зөрчид нар ч хэдийн их хүчтэй байсан боловч Баргыг нугалж чадсангүй. Тэд түүний амьдралын шинж төлөв, үндсэн нөхцөлийг өөрчилсөнгүй. Баргын оршин тогтнож ирсэн ерөнхий дүр төрх нь урьдын янзандаа үлджээ. Мөн тус районд янз бүрийн аймгууд тархай бутархай нүүдэллэн явдаг учир Мин улсын үед тэд нар ямар ч нөлөө үзүүлж чадсангүй² гэжээ.

Дараах үед тус нутгийн зүүн өмнө зүгт манжийн ноёрхол хүчтэй болж мөн хойт хязгаарт нь Амар мөрөнд Байгалийн наадахи нутгийг эзэмшиж байсан оросууд тулж иржээ. Гантөмөр манжийн захиргаанд орохыг хүссэнгүй учир харьяат ард түмнийхээ хамт босож манжийн эсрэг удаа дараа баатарлагаар байлдан орон нутгаа хамгаалж байв. Манжтай тэмцэхэд Орос улсаас тусламж авахын тулд Гантөмөр албат ардын хамт 1667 онд Оросын харьяат болж дагаар оржээ. Ийнхүү баргачууд сайн дураараа оросын эзэмшлийн нутагт нэгдэж нутгийн хил нь нэг үе их Хянганы нуруугаар Манж гүрэнтэй хил нийлж байв.³

XVII зууны дундуур оросын казакууд Амар мөрний сав газрыг эзэмших үед уул нутгийн дагуур, чивчин барга зэрэг монголчууд Манж, Хятадын алинд ч захирагдаагүй биеэ даасан отог хошууд байсан учир нутаг усны харьяагаар Орост алба татвар төлөх болжээ. Тухайлбал, Шил-

¹Вестник Маньжурии. Харбин, 1925, № 8, 10.

²Вестник Маньжурии, Харбин, 1925, № 8, 17-р тал.

³С. Д. Дылыков. Өввр Монголын ардчилсан хөдөлгөөн, 1956, УБ., 18—19-р тал.

ка голын дээд биеэр нутаглаж байсан Гантөмөр ноёныхон 1651 оноос эхлэн Орост алба «ясак» төлөх болсон ба урьд нь Манжид алба төлж байсан явдал огт үгүй байжээ.

1667 онд Манжийн хаанаас ноён Гантөмөрийг өөрийн ахын хамт Коморской цайз руу Оросын эсрэг тусгай хорооны даргаар томилон илгээсэн боловч өөрийн хорооны цэрэг ангийг удирдан орос улстай дайн байлдаан ер хийсэнгүйгээр⁴ үл барам, Манжийн түрэмгийлэн эзлэх бодлого ба түүний илбэн мэхлэх, харгислан шийтгэх арга мэхүүдэд ихэд хилэгнэн хорсож, харьяат районы олон үндэс угсааны болон баргын ард иргэдийн дайн дажны зовлонд тохиолдсон бодит байдлыг үндэслэн бодолхийлж Манжийн төрийг нэгмөсөн жигшин эсэргүүцэж орос улсыг түшин сайн дураараа дагаар орохоор бодол шийдэж өөрийн 9 эхнэртэй 30 гаруй хүүхэдтэй нэгэн аймгийн төрлийн хамт 300-500 гаруй хүнтэй, эмэгтэй хүнээс бусдыг цөм зэвсэглэж манжийн цэргийн хатуу бэхлэлтийг туулан гарч Нун голоос уул үндсэн нутаг Нэрчүүд харьж ирээд⁵ оросын харьяат иргэнд тоологдох болсон ажээ.

1650 онд манжийн захиргаа нь дагуур, монгол, түнгүүс, нар холилдон нутаглаж байсан Амар мөрний сав газарт нэвтрэн ирж, суугуул хүн амыг нутгийн гүн тийш Нуун мөрийн зүгт ухраан нүүлгэж оронд нь манжийн цэргийн харуулуудыг суулгажээ. Тэдний дотор Амар мөрний сав Шилка ба Эргүнэ гол дагуу арвин их нутаг эзэмшиж байсан Гантөмөрийн хошуу орсон бөгөөд Нуун мөрөнд нүүж очоод тэд манжийн захиргааны хавчлага дарангуйллыг эс тэвчин эсэргүүцэн босч төрсөн нутаг Нэрчүү хавьд 1655 онд дахин буцаж ирээд орост сайн дураараа дагаар орж христосын мөргөлтэй болжээ. Гантөмөр оросын харьяат болж вангийн зэрэг шагнагдсан ба оросын засгийн газраас бүх нутгийг эзэмшүүлж алба татвараас хөнгөлжээ. Гантөмөрийн хошуу 1667 онд ийнхүү уугуул нутагтаа бүрэн буцаж иржээ.

Амар мөрний сав нутгийн нөлөөтэй ван Гантөмөрийг ашиглаж уг районыг өөртөө нэгтгэх гэсэн манжийн захиргаа Гантөмөрийг оргодол босгуулд тооцож, түүнийг буцааж өгөхийг Оросын засгийн газарт 15 жилийн турш нэхэл дагал болгож байсан нь ганц Гантөмөрт биш, түүний нутаг хошуу, ард түмнийг манжийн захиргаанд нэгтгэх ба хэрэв эс бүтвэл Орост цэрэглэж халдах түрэмгий дайны шалтаг эрж байсан хэрэг болно. 1676 онд Бээжин дэх оросын элч Н. Х. Сапфариин явуулсан хэлэлцээний үед манжийн тал Гантөмөрийн асуудлаар ихэд шалтаг зааж байсан боловч Оросын тал Гантөмөрийг Манжид барьж өгөөгүй бөгөөд тэр ч өөрөө буцаж очихгүй гэж байжээ. Манжийн засгийн газар нь Орос улсын зүгээс дипломат харилцаа тогтоож, харилцан худалдаа явуулах гэсэн санаачлагыг эвдэж, Гантөмөр ванг барьж тушаах, Оросын элчийг манжийн дэг хуульд захируулах гэсэн зарчимгүй асуудлыг тулган шаардсан зэргээс болж тэдгээр болзолыг нөгөө тал хүлээж аваагүй юм. Дээр дурдсан Амар мөрний сав газар эртнээс Оросын мэдэлд байсан тул Манжид бууж сул тавьж өгөх ямар ч үндэс үгүй байжээ.⁷ Тухайлбал, Энх Амгалан хааны өөрийн нь зарлигт зөвшөөрөн хүлээсэн ёсоор 17-р зууны 40-өөд оны үед манжийн нөлөө Амар мөрөнд огт хүрээгүй байжээ.

Зөвлөлт Холбоот Улсаас 1972 онд хэвлэгдэн гарсан «Новая история Китая» хэмээх номын 59-р талд бичихдээ Орос улсын ван цолтой Гантөмөр нь Амар мөрний зүүн талд дагуур аймгийг захирч бай-

⁴А. М. Баранова. Вестник Маньчжури. Харбин. 1925. № 8—10, 21-р тал.

⁵Ёшида, Шинэ үеийн Орос, Чин улсын харилцааны түүх, 1974, Токио, 72-р тал

⁶М, И. Сладковский. Основные аспекты Маоистских фальсификаций истории. М., 1979. 25-р тал.

⁷Внешняя политика государства Цин в XVII веке. М., 1979. 320-р тал.

гаад Манжийн дарлал нухлалаас зайлан, Орос улсад өөрийн сайн дураар дагаар орсон гэж бичсэн байна. Ийм байдлын дор Ван Гантөмөр нь Манж Чин улсын түрэмгийллийн талбар болохоос нааш цааш түр зайлан гарч Нуун голд очсоны дараа Нэрчүүгийн орчим нутагт алба баригч 97 хүн үлдсэн гэдэг юм. Гантөмөр тэргүүтэй зайлан гарагсад бол дийлэнх ихэнхдээ түүний нэгэн аймгийн хүмүүс байв. Чин улсаас 1669 онд Абулинээр нэвтэрч зугатаан, Орост дагаар орж алба барих болсон 170 ардыг буцааж авахаар Манж нарын нэхэмжилсэн хүмүүсийн дотор Гантөмөрийн харъяаны 40 хүн байсан ажээ.⁸

Энэ үед тус районыг манжийн Эих Амгалан хааны зүгээс хичнээн удаа дайран довтолсон боловч Гантөмөр ард түмнээ толгойлон орж тэр бүхнийг тэсвэр хатуужилтайгаар даван туулж, эсэргүүцэн байлдаж олон удаа хүнд шархадсан боловч эр зоригтой баатарлагаар тэмцэн ялж байсан болно. Мөн Гантөмөр оросын элч Спафарийтай биечлэн уулзаж доорхи хэдэн үгээр яриагаа дуусгасан байна: Манжийн хаан Хятадад намайг баривчилж аваачих гэвэл, би Бээжин хүртэл амьд явахгүй амиа хорлож үхнэ, яагаад гэвэл, тэдэнд би ч гэсэн, эмэг эх маань ч гэсэн нэр төргүйд хүрсэн хүмүүс юм гээд тэд нарт амьд бууж өгөхгүй юм гэж ярьсан байна.⁹

Тэр үед Чин улс Гантөмөрийг Оросоос буцааж авахаар шаардаж байсан явдлаа Гантөмөрийг зэвсэглэн цэрэг дайчлуулж их хүчээр Чин улсад гэдрэг дайралт хийх явдлаас айж болгоомжлох хэрэгтэй байсан гэдгээр шалтаглаж байсан байна.

Орос, Чин хоёр улсын зөрчил дунд 1661 онд Энх Амгалан хаан Манжийн хааны ширээнд сууж нас бага балчир тул засаг төрийн хэргийг сайдууд эрхлэн шийтгэж байсан бөгөөд 1667 онд эзэн хаан өөрөө төрийн хэрэгт эхлэн ормогцоо 1669 онд Оросод оргон очиж алба баригчийг сураглахын хамт мөн аравдугаар сард Чин улсын худалдаачин хэмээх Шаралдайн зэрэг дөрвөн хүнийг Нэрчүүд туршуул хийлгэх ба 1670 оны дөрөвдүгээр сарын 15-ны өдөр Чин улсын худалдаачны нэрийдлээр Шаралдайг тагнуулын бүлгийн даргаар томилж 15 хүний хамт Оросын Нэрчүү хотод илгээн явуулж, тэд нар тэнд хүрээд тус хотын дарга Ашинскийд Энх Амгалан хааны зарлиг бичгийг гардуулан өгчээ. Тэр бичгийн агуулга нь: Монгол орноор дайрч Оросын цагаан хааны элч Хятадад ирээд байгааг ойлгож байгаа биз хэмээх үгээр сүрдүүлэн Гантөмөр бол Манж Чин улсын харъяат мөнийн тулд буцааж авъя, үүний учирт Нэрчүүгээс Бээжинд явуулж өгөхийг чухал болгов гэж бичжээ. Нэрчүүгийн дарга Ашинский тус бичгийн хариуд дөрөвдүгээр сарын 19-ний өдөр Мироновыг Чин улсын элчингийн хамт Бээжинд явуулжээ.¹⁰ Дараагаар 1673 оны хоёрдугаар сард Орос улсаас Бээжинд Николай Головинч-Милеск буюу Спафарийг бүрэн эрхт Элчингийн даргаар томилон явуулсанд Манжийн Энх Амгалан хаан хүлээн авч уулзаад Гантөмөрийг буцааж авах хүсэлт зэргийг асуудал болгон тавьсан байна. Гэвч Оросын элч уг асуудлыг хүлээн авсангүйгээр улсдаа буцсан байна.¹¹

Мөн 1675 оны хоёрдугаар сард, Москвагаас Манжид дахин элч тожилж тэр нь арван хоёрдугаар сарын 5-ны өдөр Нэрчүүд хүрч ирээд тэндээс 1676 оны нэгдүгээр сарын 23-нд Цицикарт хүрч очоод Бээжингээс ирсэн манжийн түшмэл Маадатай уулзаж ёслолын асуудал ба Гантөмөрийн асуудлаар саналаа солилцжээ.

⁸Ёшида, Шинэ үеийн Орос, Чин улсын харилцааны түүх. Токио, 1974. 72-р тал.

⁹Вестник Маньчжурии. 1925, № 8,10.

¹⁰Ёшида. Шинэ үеийн Орос, Чин улсын харилцааны түүх. Токио, 1974 72-рталд буй

¹¹Ёшида. Дурдсан зохиол. 65-р тал.

Оросын элчис тэндээсээ тус асуудлыг Бээжин орж шийдвэрлэхээр Цицикар хотоос мордож тавдугаар сарын 15-ны өдөр Бээжинд хүрч очоод Спафарийн хамт 12 зүйлийн талаар бичиг үйлдэж Манжийн хаанд асуудал тавин хариуг хүлээсэн байна.

Дараа жилийн (1677) наймдугаар сарын 29-ны өдөр Манжийн хаанаас Спафарийд амаар 3 зүйлийн хариуг тушаал өгөөд бичгээр ямар ч хариу өгсөнгүй. Тэрхүү 3 зүйлийн хариу нь 1-рт, Гантөмөрийг элч өөрөө Бээжинд дагуулж ирэх, 2-рт Оросын элч Хятадын заншлыг дагах явдал чухал. 3-рт, хятадын хилийн ойролцоо суугч орос, хятад хүмүүсийн харилцан эв найрамдалтай байх явдлыг заасан байжээ.¹²

Чин улсын талаас Гантөмөрийг буцааж авахыг хүссэн шалтгаан нь оросын хаан Амар мөрний асуудлыг хэрхэн шийдвэрлэхийг мэдэх арга болон нөгөөтэйгүүр Гантөмөрийг буцааж өгвөл түүний харъяат ард иргэд нь Манж Чин улсад дагаар орж тэд нарын газар нутаг, алба барих явдлыг юунаас ч илүү эрхэмлэж бодсон байжээ. Хэрэв Гантөмөрийг буцааж өгөхгүй бол Манж нар түүгээр шалтгаалан оросын эсрэг байлдах бодлогыг баримталж байв.¹³

Энэ далимд Энх Амгалан хаан Орос, Манж Чин улсын хоорон дахь өргөн уудам тал нутгийн нүүдэлчин монголчуудын дэвсгэр нутагт санаархаж байжээ.

1676-1680-аад оны үест Монголын феодалын зөрчилтэй байдлыг ашиглаж, Гантөмөрийг буцааж авах асуудлын зэрэгцээ манж чин улс нь Монголыг өөрийн эрхшээл нөлөөндөө татан авч колоничлох бодлого явуулж байжээ.¹⁴

Гантөмөр Оросын бүрэн эрхт элч Спафарийтэй уулзаж өөрийгөө хамгаалалтандаа байлгахыг гуйсанд, таныг Чин улсад хэрхэвч буцааж өгөхгүй гэж болзоо хийсэн тул 1684 онд Гантөмөр христосын шашинд орсон ёслолыг хийж өөрийн нэрийг Петр (Феодор), хүү Катаннэгийн нэрийг Павел гэж тус тус өөрчилжээ.

Түүний дараа жил Гантөмөр хүүгийн хамт Москва орохоор Мироновтой явж зам зуур Налоим гэдэг газарт нас барав. Гэвч хүү нь энх тунх Москвад хүрч, Орос улсын хаанд бараалхаж өөрийн нэгэн аймгийг үүрд хамгаалж өгөхийг гуйсанд, хаанаас түүнд янз бүрийн үнэ бүхий зүйлийг шагнан өгснөөр үл барам, түүнд Орос улсын ван цол хайрлаж онц эрх олгож, Москвагийн бүртгэлд бүртгэж, эрхэм угсаатны эгнээнд жагсааж зүүн Сибирийн суугуул иргэн болгов.

Энэ завсар 1685 онд Энх Амгалан хаанаас Албазины талаар оросын олзны хүнээр Оросын хаанд бичиг явуулжээ. Тэр бичгийн агуулга нь, Амар мөрнөөс оросын цэргийг ухруулж хилээ тогтоох, оргодол Гантөмөр мэтийг буцааж өгвөл улсын хил дээр арилжаа худалдаа хийхийг зөвшөөрнө гэж бичсэн байжээ.¹⁵

Тэндээс 1686 онд Гантөмөрийн хүү Павелыг уул нугтагтаан буцаж ирсний дараа зүүн Байгалын Эвенк, Якут ястнуудын тэргүүнээр Гантөмөрийн гэрээс эрхбиш сонгох болгожээ. Бас гааль татвараас хэлтрүүлсэн тусгай эрх олгож, хэрэгцээний хирээр өөрийн дураар хэрэглэх эрхтэй болгосон байна.

Ингээд 1689 оны Нерчүгийн гэрээний дараа нэгэнт хэлцэхгүй болгож Гантөмөрийнхөн бүрмөсөн Орос улсын харъяат иргэн болж, тэдний гэр бүл, үр хүүхэд; төрөл төрөгсөдийн 1000 орчим хүн ард үеийн үед

¹²Мөн тэнд 64—66-р талд.

¹³Мөн тэнд, 16 ба 66-р тал.

¹⁴Мөн тэнд, 74-р тал.

¹⁵Ёшида. Дурдсан зохиол. 77-р тал.

амар тайван амьдрах завшаан олдсон байна. Гэтэл тус районд байсан барга, дагуур аймгийн нэг хэсэг нь манжийн хилийн зааг дээр хуваагдан үлдэж одоо хүртэл хятадын их гүрний дээрэнгүй үзэл, үндэсний уусгах бодлогод хэрхэн амьдарч байгаа бодит байдлыг дурдахгүй байж болохгүй юм. Тус нутагт оршин сууж байсан дагуур, солон, эвэнки, чивчин барга овогтнуудыг манж, хятад нар орос улсад дагаар орохоос болгоомжилж зүүн тийш нь нүүлгэн Нуун мөрөн, Наймар, Ялу, Номын голын хөндий зэрэг газруудад суурьшуулжээ.

Цөөн тооны монгол болон чивчин барга нар Жарамтай, Мэргэл гол, Хайлаар гол, Имин гол, Хүйн голын хавь газруудад мал маллан, ан гөрөө хийж үлдсэн ардууд манжийн цэргийн албан хэрэгцээг хангаж чадахгүйн дээр ядуу хоосон амьдарч байжээ.

Хятадын эрх баригчид Баргын хязгаар нутгийг цэргийн явдалд ач холбогдолтой гэж үнэлж тус районд хятад хүмүүс оруулж ирүүлсэнгүй нэлээд удсан юм. Гэвч 1732 оноос 1734 онд Нуун мөрөн, Наймар, Ялу, Чоло мөрний дагуу газар тариалан, мал аж ахуйгаар амьдарч байсан ардуудаас цэрэгт татан авч эрчүүдийн тоогоор солон 1636, чивчин барга 275, дагуур 730, орчоон 359, бүгд 3 мянган эр цэргийн чадвартай хүмүүсийг гэр бүлийн хамтаар хил хязгаарыг цагдуулахаар баруун тийш Хөлөнбуйрт нүүлгэн авчирсан байна. Энэхүү цэргийг байлдаанд мордох байдлаар 50 сум, 2 жигүүр болгон зохион байгуулж манжийн хааны зарлигаар ёслолын яамнаас чивчин баргын Бальбунче гэдгийг цэргийн даргаар, солони Дабахаиг орлогч даргаар тус тус томилсон байна.

Ийнхүү Баргын районыг манж, хятад нар түрэмгийлэн эзэлж «Орос, Монголын довтолгооноос хамгаалах» нэрийдлээр манжийн хил хязгаарын дагуу газрыг цэргийн хуаран болгов. Өөрөөр хэлбэл, манж нар Баргыг Амар мөрөн, Эргүнэ голын чиглэл дэх Оросын эсрэг цэрэг дайны халхавч талбар болгохын хамт цэргийн агт морь, хүнсний мал сүргийн бэлчээр, хадлан тариалангийн нутаг болгон хувиргав. Хожим нь Хайлаар голд Хайлар хотыг Баргын төв болгон байгуулж Цицикараас засаг захиргааны талаар өөрчлөн Хөлөнбуйр, Баргыг бүрэн өөртөө засах мужийн байдалд үлдээсэн байна. Энэ үед Баргыг чивчин барга, солон барга гэж нэрлэж байсан болно.

XVII зууны сүүлч үед, Өөлдийн Галдан бошгот хааны тэмцлийн үед хоёр сум өөлд ардыг Ялу голын хөвөөгөөр нутаглуулан 1733 онд нүүлгэж Баргын нутгийн Шинэхэн голын ба Имин гол орчим газарт нутаг олгож өгсөн байна. Мөн 1753 онд Амарсанаагийн цэргийн үлдсэн зарим өөлдүүдийг энэ нутагт нүүлгэн ирүүлжээ. 1734 онд халхын Цэцэн хаан аймагт харъяалагдаж байсан буриадуудаас заримыг манж, хятад түшмэд ов явууллага хийж Хөлөнбуйрын нутагт нүүлгэн аваачиж баргын зүүн, баруун хоёр гар найман хошуу 24 сум болгон зохион байгуулж шинэ барга гэж нэрлэх болжээ.

Тийнхүү манж, хятадын талаас хүний олон, цэрэг зэвсгийн хүчээр бурангуйлан түрэмгийлж тус районы ард түмнийг бусниулан газар орныг нь булаан дээрэмдэж гүн зузаан зовлонт амьдралыг эдлүүлж байжээ. Аль 1632 оноос эхлэн манжийн эзэн хаан тус районы нутаг дэвсгэрийг эзлэн, байгалийн баялаг, мал аж ахуйд шунахайран манжид алба бариулахаар зорилго тавьж Орос улсыг олон мянган цэргээр түрэмгийлэн дайрах, сүрдүүлэг үзүүлэх ба Нэрчүү хот зэрэг газруудад нь манжийн тагнуулаар Шаралдай тэргүүтэй 15 хүнийг илгээж, нутгийн ард түмнийг үймүүлэн хатгаж манжид «сайн дураар» дагаар оруулах ажлыг зохион, Гантөмөрийг гэр бүлээр буцаан авч хүйс тэмтрэх бодлогоор хоёр улсын хооронд элч томилон явуулах ба хааны зарлигийн бичгээр тушаан зарлигдаж тусгай хүнээр Гантөмөрийг шууд авчруулахыг оролдох зэргээр

илбэж мэхэлж, айлган сүрдүүлэх ажлыг хослон явуулж, хоёр улсын хоорондын харилцаа, худалдааг таслан хориглож байсан ажээ.

ВЫСТУПЛЕНИЯ ГАНТУМУРА ПРОТИВ ЦИНОВ

(Резюме)

Ж. Ульзий.

С 1650 года маньчжурская династия предпринимает попытки распространить свое влияние на территорию бассейна реки Амур, где проживали многочисленные монгольские племена. Насильно переселяя их вглубь страны, цинское правительство на месте установило свою администрацию и военные посты, в целях дальнейшего вторжения на территорию России.

Люди из хошуна Гантумура, попавшие под маньчжурское господство, в 1655 году восстали и возвратились на родину (район нынешнего Нерчинска), где Гантумур признал себя российским подданным, принял христианство, получил титул князя и льготные подати.

На протяжении 15 лет маньчжуры требовали от царской России возврата Гантумура, чтобы, используя его влияние, подчинить себе область его обитания. Безуспешно заканчивались требования маньчжурских послов о выдаче Гантумура, также безрезультатными были попытки вооруженного нападения на его территорию-часть русских владений в Приморье.

После смерти Гантумура, в 1686 году его сына провозгласили главой эвенков и якутов, проживающих к востоку от Байкала, и в 1689 году его люди окончательно приняли российское подданство.